



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/425

Зуунмод

Хяналт шалгалтын ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Амьтны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт явуулах, хууль бусаар тарвага агнах зөрчлийг таслан зогсоох, тусгай зориулалтаар ан агнах, барих үйл ажиллагаанд хяналт тавих зорилготой ажлын хэсгийн удирдамжийг нэгдүгээр, хяналт шалгалт зохион байгуулахад шаардлагатай шатахууны тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хяналт шалгалтын арга хэмжээнд шаардагдах 2,891,400 (хоёр сая найман зуун ерэн нэгэн мянга дөрвөн зуу) төгрөгийн зардлыг аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн 2022 оны 09 дүгээр сарын 25-ны дотор танилцуулахыг Байгаль газрын дарга орчин, аялал жуулчлалын газрын дарга (Ж.Даш-Яйчил)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР